

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ ТӨВИЙН ДҮРЭМ

Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл

- 1.1. Эвлэрүүлэн зуучлах төв /цаашид “Төв” гэх/ нь Улаанбаатар хотын Худалдааны Танхим /цаашид “УБХТ” гэх/-ын дэргэдэх нэгж бөгөөд УБХТын дэргэдэх Арбитр /цаашид “Арбитр” гэх/-ын дарга Төвийн дарга байна
- 1.2. Төв нь иргэд, байгууллага хоорондын эдийн засаг, бизнесийн харилцаатай холбоотой иргэний эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй.
- 1.3. Дүрмийн 1.2-т заасан маргааныг эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр шийдвэрлэх эрх гагцхүү эвлэрүүлэн зуучлагчид хадгалагдана.
- 1.4. Төв нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Эвлэрүүлэн зуучлалын тухай Монгол Улсын хууль болон бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

Хоёрдугаар бүлэг Төвийн зорилго, зарчим, бүрэн эрх

- 2.1. Төвийн зорилго нь иргэд, байгууллага хоорондын эдийн засаг, бизнесийн харилцаатай холбоотой эрх зүйн маргааны талуудын ашиг сонирхолд нийцэхүйц шийдлийг олоход нь зуучлан, маргааныг эвийн журмаар, шуурхай, зардал багатай шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.
- 2.2. Төв нь үйл ажиллагаандаа Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 5.2-т заасан зарчмаас гадна хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэх, шударга ёсыг сахих, нээлттэй, ил тод, ёс зүйтэй байх зарчмыг баримталж ажиллана.
- 2.3. Төв дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 2.3.1. бизнесийн маргааны талуудыг эвлэрүүлэн зуучлах ажлыг зохион байгуулах;
 - 2.3.2. эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах, гэрчилгээ олгох, бэлтгэх, давтан сургах ажлыг зохион байгуулах;
 - 2.3.3. эвлэрүүлэн зуучлагчийг бүртгэх, олон нийтэд нээлттэй зарлах ажлыг зохион байгуулах;
 - 2.3.4. төрийн болон төрийн бус байгууллага, төсөл хөтөлбөр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлтэй өөрийн бүрэн эрхийн хүрээнд хамтран ажиллах;

2.3.5. эвлэрүүлэн зуучлах чиглэлээр хууль тогтоомж, бодлогын баримт бичиг болон дүрэм, журмын төсөлд санал зөвлөмж өгөх, байр сууриа илэрхийлэх;

2.3.6. эвлэрүүлэн зуучлалын тухай хууль тогтоомж сурталчлах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр мэдээлэл хийх, сургалт зохион байгуулах, бусад байгууллага, иргэнтэй хамтран ажиллах;

2.3.7. олон улсын эвлэрүүлэн зуучлалын байгууллагуудтай ажил хэрэгч холбоо тогтоон хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;

2.3.8. УБХТ болон төвийн үйл ажиллагаатай харшлахгүй бусад үйл ажиллагаа явуулах.

Гуравдугаар бүлэг Эвлэрүүлэн зуучлах төвийн удирдлага, зохион байгуулалт

3.1 Төвийн удирдах дээд байгууллага нь УБХТ-ын Удирдах зөвлөл /цаашид “Удирдах зөвлөл” гэх/ байна.

3.2. Удирдах зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.2.1. төвийг үүсгэн байгуулах, татан буулгах;

3.2.2. төвийн дүрмийг батлах, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах;

3.2.3. төвийн даргыг сонгох, чөлөөлөх;

3.2.4. эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам, эвлэрүүлэн зуучлагчийн зардал, хураамж, ажлын хөлс, урамшууллын журмыг батлах;

3.2.5. эвлэрүүлэн зуучлагчийн нэрсийн жагсаалтыг батлах;

3.2.6. эвлэрүүлэн зуучлагчийн эрхийг түдгэлзүүлэх, хасах, гэрчилгээг хүчингүй болгох, нэрсийн жагсаалтаас хасах.

3.3. Төвийн тэргүүн нь арбитрын дарга байна.

3.4. Төвийн даргыг Удирдах зөвлөлөөс 3 жилийн хугацаагаар томилох бөгөөд улируулан томилж болно.

3.5. Төвийн дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.5.1. төвийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

3.5.2. төвийг гадаад, дотоодод төлөөлөх;

3.5.3. удирдах зөвлөлийн хуралд эрхлэх хүрээнийхээ асуудлыг хэлэлцүүлэх;

- 3.5.4. төвийн ажилтныг ажилд томилох, ажлаас чөлөөлөх;
 - 3.5.5. бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал, шийдвэр гаргах;
 - 3.5.6. эвлэрүүлэн зуучлагчид гаргах өргөдөл, эвлэрлийн гэрээний болон мэдэгдэх хуудасны загварыг батлах;
 - 3.5.7. төвийн ажлын албаны даргыг томилох, чөлөөлөх;
 - 3.5.8. удирдах зөвлөлд жилд 1 удаа ажлаа тайлагнах;
 - 3.5.9. эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн дүрмийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих.
- 3.6. Төвийн өдөр тутмын ажлыг арбитрын ажлын албаны дарга удирдлагаар хангана.
- 3.7. Ажлын албаны дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 3.7.1. төвийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах;
 - 3.7.2. төвд ажиллах ажилтнуудыг сонгон шалгаруулж арбитрын даргад танилцуулах;
 - 3.7.3. төвийн даргын эзгүйд түр орлох;
 - 3.7.4. төвийг төлөөлөн гадаад дотоодын иргэд, байгууллага, аж ахуйн нэгжтэй харилцах;
 - 3.7.5. ажлаа сард 1 удаа төвийн даргад тайлагнах;
 - 3.7.6. төвийн эвлэрүүлэн зуучлагч, захиргааны ажилтнуудаас үйл ажиллагааны тайлан авах, үнэлгээ өгөх;
 - 3.7.7. эвлэрүүлэн зуучлагчаар ажиллах эрхийг сунгах, чөлөөлөх асуудлыг шийдвэрлүүлэхээр Удирдах зөвлөлд санал гаргах;
 - 3.7.8. төвийн бүтэц, орон тоо, үйл ажиллагааны талаарх саналаа төвийн даргад хүргүүлэх.

Дөрөвдүгээр бүлэг **Эвлэрүүлэн зуучлагч болох эрх, шалгуур**

4.1. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8.2-т зааснаар төвийн ажлын албаны дарга нь зуучлагчийн эрхтэй, дараахь шаардлага хангасан эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулж Удирдах зөвлөлд танилцуулж зуучлагчдын нэрсийн жагсаалтад бүртгэнэ:

- 4.1.1. 35-аас дээш насны, ял шийтгүүлж байгаагүй;
 - 4.1.2. мэргэжлээрээ 7-оос доошгүй жил ажилласан;
 - 4.1.3. эвлэрүүлэн зуучлах зуучлагчийн сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан;
 - 4.1.4. харилцааны ур чадвартай, итгэл даасан байх;
 - 4.1.5. эвлэрүүлэн зуучлалыг сурталчлах, олон нийтэд таниулах ажилд оролцох хүсэл сонирхолтой байх.
- 4.2. Дараахь нөхцөлд эвлэрүүлэн зуучлагчаар ажиллах эрх үүрэг дуусгавар болно:
- 4.2.1. зуучлагч өөрөө татгалзах хүсэлт гаргасан;
 - 4.2.2. нас барсан эсхүл эрх зүйн чадамжгүй болсон;
 - 4.2.3. хууль тогтоомж, ёс зүйн дүрэм болон бусад холбогдох дүрэм журам зөрчсөн;
 - 4.2.4. хууль тогтоомжид заасан бусад.

Тавдугаар бүлэг Төвийн эд хөрөнгө, санхүүжилт

- 5.1. Төвийн эд хөрөнгө нь үндсэн ба эргэлтийн хөрөнгө, тэдгээртэй адилтгах бусад активаас бүрдэнэ.
- 5.2. Төв нь ашиг олох зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа явуулахгүй боловч хуулийн хүрээнд үйлчилгээ үзүүлж өөрийгөө санхүүжүүлж болно.
- 5.3. Төвийн санхүүжилт нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:
- 5.3.1. арбитраас шилжүүлэн өгсөн эд хөрөнгө;
 - 5.3.2. эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамж;
 - 5.3.3. төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд зориулсан хөрөнгө
 - 5.3.4. иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн бэлэг, хандив, тусламж

Зургадугаар бүлэг Нууц хадгалах

- 6.1. Төвийн нарийн бичгийн дарга болон эвлэрүүлэн зуучлагчид нь эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны шугамаар олж мэдсэн иргэн, байгууллагын нууцыг хадгалах үүрэгтэй.

Долдугаар бүлэг

Бусад

7.1.Төв нь насанд хүрээгүй болон өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, төлбөрийн чадваргүй иргэнд хөнгөлөлттэй нөхцөлөөр үйлчилж болно.

7.2. Дүрмийн 6.1-д зааснаас болон Удирдах зөвлөлөөс шийдвэрлэснээс бусад тохиолдолд эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээг төлбөртэй үзүүлнэ.

7.3. Энэхүү дүрэм нь Удирдах зөвлөлийн хурлаар батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.